



Г САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
С.БОЛОРЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.13 № 01/11 ДУА -2017/103/СТА -ТЦ/З

Г Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Насжилт өндөртэй 1,560,211.00 /Нэг сая таван зуун жаран мянга хоёр зуун арван нэг/ төгрөгийн авлага, 351,440.00 /Түрвэн зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун дөчин нэг/ төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.6-д /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийтуулэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг зөрчсөн байна.

2. Жилийн эцсийн тооллогоор 1,377,092.00 /Нэг сая гурван зуун далан долоон мянга ерон хоёр/ төгрөгийн хөрөнгө дутагдуулсан байна.

Энэ нь ажилтантай байгуулсан "Эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх гэрээ"-ний 3.1-т /Ажилтан нь баримтаар, албан ажлын зориулалтаар хүлээн авсан эд зүйлсийг зориулалтын дагуу, ариг гамтай ашиглана/ заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.2-т /Өмч, хөрөнгийг зохих шийдвэргүйгээр бусдад зүй бусаар ашиглуулсан, зах зээлийн үнээс ондөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олжс бэлтгэсэн/, 4.1.4-т /Байгууллага, иргэдтэй

000000025

Үүссэн материалаг дүнтэй буюу насыжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй/заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, насыжилт өндөртэй авлагыг барагдуулах, хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;
2. Тооллогоор дутагдуулсан эд хөрөнгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, цаашид хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга С.Болоржаргал, нягтлан бодогч З.Цэдэнрулам нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ



¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/